



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон. 206, 207, 210, 213 тоот
7-р баг. Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас: 70592439, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2023. 11. 02. № 02/188

танай _____ -ны № _____ -т

70318.

Мандалговь

**ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Г.БАТЖАРГАЛ ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийлээ.

Аудитаар илэрсэн зөрчилд тогтоосон төлбөрийн актыг хүргүүлж байна. Тогтоосон хугацаанд зөрчлийг арилган хариу ирүүлэхийг хүсье.

Хавсралт 2 хуудас

ДАРГА Р.МӨНХТОГТОХ



0012032761

аасан Төрийн аудитын
Нийгмийн даатгалын
ан, төсвийн гүйцэтгэлд
нааян есөн/ төгрөгийн

52,000.00 /Тавин хоёр

т /Төсвийг үр ашигтай,
ын 2019 оны 6 дугаар
лбөр олгох журам"-ын
илласан хоногийн тоог
эн хуанлийн хоногоор
эн өдрийг нэгтгэн нэг
толтын зардлын тариф
албан хаагчийн албан
аймгийн төвд 28,000
өгөөр, байрны зардлыг
таанбаатар, Эрдэнэт,
юсугай/ заасныг тус тус

2. Албан хаагчид төрийн албанд ажилласан жилийн нэмэгдлийг 18,489 /Арван найман мянга дөрвөн зуун нааян есөн/ төгрөгөөр илүү тооцож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;/, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 2-т /Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно/, /Төрийн

0012052485


**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 102

Н/1270318.

Мандалговь

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийлээ.

Аудитаар нийт 70,489.00 /Далан мянга дөрвөн зуун наян есөн/ төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

1. Албан хаагчдад албан томилолтын хоолны зардлыг 52,000.00 /Тавин хоёр мянган/ төгрөгөөр илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.4-т /Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно/, Сангийн сайдын 2022 оны "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" 120 дугаар тушаалын 1-т /Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг суманд 24,000 төгрөг, аймгийн төвд 28,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 32,000 төгрөгөөр, байрны зардлыг суманд 40,000 төгрөг, аймгийн төвд 90,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 110,000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай/ заасныг тус тус зөрчсөн байна.

2. Албан хаагчид төрийн албанд ажилласан жилийн нэмэгдлийг 18,489 /Арван найман мянга дөрвөн зуун наян есөн/ төгрөгөөр илүү тооцож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;/, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 2-т /Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно/, Төрийн

алба хаасан хугацаа 12 дахь жил (133 – 144 сар) бол албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь 11 хувь байна!

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т /Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно./, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д/Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон/ заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан хаагчдад илүү олгосон 70,489.00 /Далан мянга дөрвөн зуун наян есөн/ төгрөгийг Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд төвлөрүүлэх;

Актын биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Г.Батжаргал, ахлах нягтлан бодогч Р.Нэргүй нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР



Д.ДОЛЖИНСҮРЭН

БАТАЛГААЖУУДСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

ААБ 5.2: АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫГ ҮНЭЛЖ, ШИЙДВЭРЛЭХ

Байгууллагын нэр: Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

Тайлант хугацаа: 2023 оны 6 сар

№	Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Асуудлыг шийдвэрлэхэд үндэслэл болгосон		Асуудлыг шийдвэрлэсэн байдал			Гаргасан шийдэл
				Холбогдох хууль тогтоомжийн нэр, заалт	Холбогдох стандартын нэр, заалт	Аудиторын санал	Аудитыг хянан удирдах ажилтнуудын санал		
							Менежер	Тэргүүлэх аудитор	
А	1	2	3	5	6	7	8	9	10
1	Албан томилолтын зардал	Албан хаагчдад албан томилолтын хоолны зардлыг 52,000 төгрөгөөр илүү олгосон.	52,000.00	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.4-т /Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно/, Сангийн сайдын 2022 оны "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" 120 дугаар тушаалын 1-т /Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг суманд 24,000 төгрөг, аймгийн төвд 28,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 32,000 төгрөгөөр, байрны зардлыг суманд 40,000 төгрөг, аймгийн төвд 90,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 110,000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай/	УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн тодруулга, УСНББОУС-15 тодруулга ба толилуулга	Төлбөрийн акт	Төлбөрийн акт	Төлбөрийн акт	Төлбөрийн акт
2	Цалингийн зардал	Албан хаагчид төрийн албанд ажилласан жилийн нэмэгдлийг 18,489 төгрөгөөр илүү тооцож олгосон	18,489.00	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 2-т / Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно/, /Төрийн алба хаасан хугацаа 12 дахь жил (133 – 144 сар) бол албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь 11 хувь байна/	УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн тодруулга, УСНББОУС-15 тодруулга ба толилуулга	Төлбөрийн акт	Төлбөрийн акт	Төлбөрийн акт	Төлбөрийн акт
3	Халаалтын зардал	Төсвийн жилийн дундуур халаалтын зардлыг нэмэгдүүлсэн гэрээ байгуулсан	1,818,432.00	Төсвийн тухай хуулийн 6.2.5.-д /төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх/, 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/,	УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн тодруулга, УСНББОУС-15 тодруулга ба толилуулга	Зөвлөмж хүргүүлэх	Зөвлөмж хүргүүлэх	Зөвлөмж хүргүүлэх	Зөвлөмж хүргүүлэх
Нийт дүн			1,888,921.0						

Бэлтгэсэн: Аудитор

Хянасан: Аудитын менежер

Хоёр дахь шатанд хянасан: Тэргүүлэх аудитор

Д.Должинсүрэн

Х.Наранцацрал

Р.Мөнхтогтох

Огноо:

Огноо:

Огноо:

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

Тайлант хугацаа: 2023 оны 6 сар

№	Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын холбогдох хүний	
								Албан тушаал	Овог нэр
А	1	3	4	5	6	7	8	9	10
1	Албан томилолтын зардал	Албан хаагчдад албан томилолтын хоолны зардлыг 52,000 төгрөгөөр илүү олгосон.	52,000.00	Нөхөн төлүүлэх хугацаатай төлбөрийн акт тогтоохоор болсон	Шинээр үйл ажиллагааны нягтлан бодогчтой болоод анзаараагүй гаргасан байна.	Аудиторын саналыг хүлээн зөвшөөрч 2023 оны 11 сарын 25 дотор төлөхөөр болсон	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Г.Батжаргал, Р.Нэргүй
2	Цалингийн зардал	Албан хаагчид төрийн албанд ажилласан жилийн нэмэгдлийг 18,489 төгрөгөөр илүү тооцож олгосон	18,489.00	Нөхөн төлүүлэх хугацаатай төлбөрийн акт тогтоохоор болсон	Хүний нөөцийн программаас ажилласан сар хүрсэн албан хаагчдын төрд ажилласан жилийг боддог юм мэдээлэл орохдоо алдаа гарсан бололтой	Аудиторын саналыг хүлээн зөвшөөрч 2023 оны 11 сарын 25 дотор төлөхөөр болсон	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Г.Батжаргал, Р.Нэргүй
3	Халаалтын зардал	Төсвийн жилийн дундуур халаалтын зардлыг нэмэгдүүлсэн гэрээ байгуулсан.	1,818,432.00	Батлагдсан төсвийн дагуу зарлага гаргаж, өглөг үүсгэхгүй байх	Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолоор батлагдсан тарифаар гэрээг шинэчлэн байгуулж, өглөг үүссэн, 2023 оны 3 улиралаар тодотгол хийлгэж, одоогоор өглөггүй болсон.	Цаашид анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр болсон	Батлагдсан төсвийн дагуу зарлага гаргаж, төсвийн жилийн дундуур зарлага нэмэгдүүлэх, аливаа шийдвэр гаргахгүй байх	Дарга, нягтлан бодогч	Г.Батжаргал, Р.Нэргүй
Нийт дүн			1,888,921.00						

Бэлтгэсэн: Аудитор



Д.Должинсүрэн

Дарга



Г.Батжаргал

Хянасан: Аудитын менежер



Х.Наранцацрал

Нягтлан бодогч:



Р.Нэргүй

Хоёр дахь шатанд хянасан: Тэргүүлэх аудитор

Р.Мөнхтогтох

